



Үнэт цаасны зах зээл

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2007 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

“Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай”
Г журамд нэмэлт, өөрчлөлт оруулах Г

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн 6.2.2 дахь заалт,
“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хорооны 2006 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан
“Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” журамд дөр дурдсан агуулга бүхий
заалтыг нэмсүгэй:

1/ 4.8.7, 4.8.8 дахь заалт:

“4.8.7. Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-д бүртгэлтэй үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт
оруулахад Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг тус
тус бүрэн биелүүлсэн тухай тодорхойлолт;

4.8.8. Ногдол ашиг хуваарилсан байдал, хуваарилсан ногдол ашиг үлдэгдэлтэй бол уг
хөрөнгийг ҮЦТТХТ-д холбогдох хувьцаа эзэмшигчийн нэр дээр байршуулсан баримт”;

2/ 5.1.6, 5.1.7 дахь заалт:

“5.1.6. Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-д бүртгэлтэй үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт
оруулахад Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг тус
тус бүрэн биелүүлсэн тухай тодорхойлолт.

5.1.7. Ногдол ашиг хуваарилсан байдал, хуваарилсан ногдол ашиг үлдэгдэлтэй бол уг
хөрөнгийг ҮЦТТХТ-д холбогдох хувьцаа эзэмшигчийн нэр дээр байршуулсан баримт”.

3/ 6.2.4 дэх заалт:

“6.2.4. Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-д бүртгэлтэй үнэт цаасыг бүртгэлээс хасахад
Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг тус тус бүрэн
биелүүлсэн тухай тодорхойлолт”.

4/ 6.4.5. дахь заалт:

“6.4.5. Ногдол ашиг хуваарилсан байдал, хуваарилсан ногдол ашиг үлдэгдэлтэй бол уг
хөрөнгийг ҮЦТТХТ-д холбогдох хувьцаа эзэмшигчийн нэр дээр байршуулсан баримт”.


2. Мөн журмын 2.7.9 болон 2.7.10 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

2.7.9 дэх заалтын “тухай баримт бичиг” гэсний дараа “тэргүүн ээлжинд худалдан авах
давуу эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн тухай
тэмдэглэл, гарсан шийдвэрийн хувь” гэж, 2.7.10 дахь заалтын “энэ үнийг тогтоосон үндэслэл”
гэсний дараа “энэ үнэ нь үнэт цаасыг арилжаалж эхлэхээс өмнөх сүүлийн 6 сарын зах зээлийн

дундаж ханшнаас, сүүлийн 6 сард арилжаалагдаагүй бол нийт арилжааны дундаж ханшаас багагүй байна” гэж тус тус нэмсүгэй.

3.Журамд орсон өөрчлөлтийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэж нийтэд сурталчлахыг Ажлын алба /О.Ганбат/ -нд даалгасугай.

4.Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т үүрэг болгосугай.



Д.БАЯРСАЙХАН

О.ГАНБАТ